

Дуулгах сонин

Олон улсын явуулын үзэсгэлэн Монголд

Н.ДАЯН

Монгол, Австралийн хооронд дипломат харилцаа тогтоосны 45 жилийн ой энэ онд тохиож байгаа. Энэ хүрээнд Австралийн Элчин сайдын яамны урилгаар тус улсын уугуул соёл, урлагийн нэрт төлөөлөгч, хөгжимчин, дуучин, бүжиг дэглээч, сурган хүмүүжүүлэгч Матью Дойл энэ сарын 25, 26-нд Монголд айлчлах гэж байна. Тэрээр Улаанбаатар чуулгын уран бүтээлчдэд Австралийн уугуул иргэдийн хөгжим, бүжгийн чиглэлээр сургалт явуулж, туршлага солилцох ажээ. Мөн энэ сарын 25-нд “Эртний мастерууд, Австралийн холтосны агуу зураачид” олон улсын явуулын үзэсгэлэн гарна. Үзэсгэлэнд багтсан бүтээлүүд Австралийн соёлын үнэт өвд тооцогддог. Австралийн Үндэсний музейн цуглуулгад багтдаг эдгээр зургаар Австрали олон улсад явуулын үзэсгэлэн гаргасаар иржээ. Австралийн хойд хэсэгт оршин суудаг Арнхем нутгийн уугуул иргэд хэдэн мянган жил бүтээж ирсэн холтос дээрх зургийг ХХ зууны сүүлээр дэлхийн урлагийн агуу уламжлал хэмээн хүлээн зөвшөөрчээ. Модны холтос дээр шороогоор зуурсан зосоор зурсан учир эдгээр зургийг газар эхийн бүтээл гэж хэлж болно.